



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланд хийсэн  
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/87/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Гантулга

Утас: 99439613

Цахим хаяг: gantulgats@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>5</b>
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	<b>12</b>
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
<b>3.5.1 Төсвийн төлөвлөлт</b> .....	<b>13</b>
<b>3.5.2 Төсвийн гүйцэтгэл</b> .....	<b>14</b>
<b>3.5.3 Нэмэлт төсөв</b> .....	<b>14</b>
<b>3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн</b> ...	<b>Error! Bookmark not defined.</b>
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	<b>14</b>
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	<b>14</b>
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	<b>15</b>
<b>4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	<b>15</b>
<b>4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	<b>15</b>
<b>4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	<b>15</b>
<b>4.5 Завсрын аудитын талаар 2022 онд завсрын аудит хийгдээгүй, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хянасан.</b> .....	<b>15</b>
<b>4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн</b> .....	<b>15</b>
<b>4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал</b> .....	<b>16</b>
5.1 Залруулсан алдаа .....	

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
УОК-	Улсын онцгой комисс
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
МУ	Монгол улсын
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА У.ХИШИГДЭЛГЭР  
ТАНАА

2023.02.16 № 02/46  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХЯЗГААРЛАЛТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар шүүхийн шийдвэрээр эгүүлэн ажилд нь тогтоосон ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг Эрүүл мэндийн төвийн төсвөөс гаргасан, эмийн дэлгэрэнгүй тайлан гаргаж тооцоо бодоогүй, эмийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас бөөн дүнгээр орлого авч зарлага гаргадаг тендерээр эм нийлүүлж байгаа компаниудын эм нийлүүлэх эрх, гэрээтэй эсэх тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэл эмх цэгцгүй, хариуцах эзэн тодорхой бус авлага үүсгэсэн зэрэгтэй холбоотой 134.4 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь урьд жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлэг буюу улсын төсвөөс шууд санхүүждэг байсан ба тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар санхүүждэг болсон байна. Ингэснээр нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

#### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### **Бусад асуудлын хэсэг**

Нийт ор хоног өнгөрсөн онд 6452 байсан бол тайлант онд 2797 буюу 57 хувиар буурсан нь цар тахлын жилд өвчлөл ихтэй байсантай холбоотой байна.

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 85 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

АЛТАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН  
ТӨВИЙН ДАРГА У.ХИШИГДЭЛГЭР  
ТАНАА

2023.02.16 № 02/46  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### ХЯЗГААРЛАЛТТАЙ ДҮГНЭЛТ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар шүүхийн шийдвэрээр эгүүлэн ажилд нь тогтоосон ажилтны ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг Эрүүл мэндийн төвийн төсвөөс гаргасан, эмийн дэлгэрэнгүй тайлан гаргаж тооцоо бодоогүй, эмийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас бөөн дүнгээр орлого авч, зарлага гаргадаг, тендерээр эм нийлүүлж байгаа компаниудын эм нийлүүлэх эрх, гэрээтэй эсэх тодорхой бус, анхан шатны баримтын бүрдэл эмх цэгцгүй, хариуцах эзэн тодорхой бус авлага үүсгэсэн зэрэгтэй холбоотой 134.4 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, АДБОУС 1250, иж бүрэн, тасалбар болголт нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Эрүүл мэндийн төв нь урьд жилүүдэд тусгай зориулалтын шилжүүлэг буюу улсын төсвөөс шууд санхүүждэг байсан ба тайлант хугацаанд эрүүл мэндийн даатгалын сангаас үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний тарифаар санхүүждэг болсон байна. Ингэснээр нэг иргэнээр тооцсон санхүүжилт, үндсэн тусламж үйлчилгээний санхүүжилт, нэмэлт орлогын эх үүсвэрээр санхүүжих зарчимд шилжсэн байна.

#### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Нийт ор хоног өнгөрсөн онд 6452 байсан бол тайлант онд 2797 буюу 57 хувиар буурсан нь цар тахлын жилд өвчлөл ихтэй байсантай холбоотой байна.

Тус байгууллага нь тайлант онд 7 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 74 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 85 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

  
Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>83,468,462.51</u></b>	<b><u>57,411,802.20</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	520,268.26	25,156,596.96
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	520,268.26	25,156,596.96
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	520,268.26	25,156,596.96
31211	Төрийн сангийн харилцах	520,268.26	25,156,596.96
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	38,717,104.21	1,335,104.21
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	1,315,104.21	1,315,104.21
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	37,402,000.00	20,000.00
3351	Байгууллагаас авах авлага	37,402,000.00	20,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	44,231,090.04	30,920,369.29
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	23,206,482.00	18,945,094.80
35130	Эм боох материал	23,206,482.00	18,945,094.80
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	17,429,608.04	8,380,274.49
35410	Бичиг хэргийн материал	1,432,150.00	1,099,100.00
35420	Аж ахуйн материал	11,751,384.04	4,908,175.49
35460	Хүнсний материал	2,214,000.00	1,617,600.00
35470	Бусад хангамжийн материал	1,819,074.00	755,399.00
35600	Мал амьтад	3,595,000.00	3,595,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>378,925,031.63</u></b>	<b><u>445,486,652.77</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	378,925,031.63	445,486,652.77
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	342,925,031.63	409,486,652.77
39201	Барилга, байгууламж, орон сууц	266,465,857.00	266,465,857.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-20,529,288.12	-26,747,384.16
39203	Авто-тээврийн хэрэгсэл	66,031,833.00	141,746,129.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-40,879,861.20	-51,173,499.72
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	181,095,688.00	206,831,842.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-123,744,702.15	-141,378,816.46
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20,972,220.00	20,972,220.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,265,064.90	-10,200,680.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,631,550.00	2,824,185.29
39217	Ном	146,800.00	146,800.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	36,000,000.00	36,000,000.00
39301	Програм хангамж	550,000.00	550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-550,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	36,000,000.00	36,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>462,393,494.14</u></b>	<b><u>502,898,454.97</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>32,440,928.00</u></b>	<b><u>1,566,070.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	32,440,928.00	1,566,070.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	32,440,928.00	1,566,070.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	32,440,928.00	1,566,070.00

41361	Байгууллагад төлөх өглөг	32,440,928.00	1,566,070.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>429,952,566.14</u></b>	<b><u>501,332,384.97</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	429,952,566.14	<u>501,332,384.97</u>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	349,821,565.00	349,821,565.00
51101	Өмч: - төрийн	349,821,565.00	349,821,565.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-31,039,635.21	40,340,183.62
51210	Өмнөх үеийн үр дүн	-31,039,635.21	-31,039,635.21
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	71,379,818.83
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111,170,636.35	111,170,636.35
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>462,393,494.14</u></b>	<b><u>502,898,454.97</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>737,798,357.02</b>	<b>800,922,620.09</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>34,284,004.02</b>	<b>250,730,647.09</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	34,284,004.02	250,730,647.09
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,284,004.02	250,730,647.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	102,655,197.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	30,690,300.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	34,284,004.02	117,385,150.09
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>703,514,353.00</b>	<b>550,191,973.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	53,182,733.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	27,385,000.00	35,666,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,385,000.00	35,666,200.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	418,835,600.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	418,835,600.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	204,111,020.00	514,525,773.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	204,111,020.00	514,525,773.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>712,668,429.42</b>	<b>729,542,801.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>712,668,429.42</b>	<b>729,542,801.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	678,227,598.42	727,368,669.56
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	367,667,499.21	381,892,189.94
210101	Үндсэн цалин	367,667,499.21	375,719,109.50
210102	Нэмэгдэл	00.00	5,236,080.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	937,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	49,103,394.00	46,909,960.12
210201	Тэтгэврийн даатгал	49,103,394.00	32,241,189.35

210202	Тэтгэмжийн даатгал	00.00	3,666,350.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	2,939,987.77
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	720,527.77
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	7,341,905.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,729,169.00	29,825,868.30
210301	Гэрэл, цахилгаан	416,669.00	399,868.30
210302	Түлш, халаалт	18,492,500.00	23,606,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,820,000.00	5,820,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	45,993,302.32	82,389,863.55
210401	Бичиг хэрэг	4,224,810.00	6,171,100.00
210402	Тээвэр, шагахуун	39,622,905.00	54,019,850.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,867,097.32	1,262,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	278,490.00	183,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,398,755.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	19,353,858.55
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	142,671,850.38	137,946,253.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	136,417,340.38	121,437,613.50
210502	Хоол, хүнс	6,254,510.00	12,288,640.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	4,220,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	707,000.00
210604	Урсгал засвар	00.00	707,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	756,000.00	2,483,800.00
210702	Дотоод албан томилолт	756,000.00	2,483,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	806,325.00	4,709,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,791,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	35,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,115,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	405,400.00	658,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	46,500,058.51	40,504,734.15
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,301,950.00	2,600,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	33,198,108.51	37,904,734.15
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	34,440,831.00	2,174,131.70
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32,800,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,800,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,640,831.00	2,174,131.70
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,640,831.00	2,174,131.70
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>25,129,927.60</b>	<b>71,379,818.83</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	997,240.00	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	997,240.00	00.00

4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-997,240.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<b>24,132,687.60</b>	<b>71,379,818.83</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	/Төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>667,183,353.00</b>	<b>720,939,470.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>170,747,497.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	<b>170,747,497.00</b>
120009	Бусад орлого	00.00	<b>170,747,497.00</b>
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО</b>	<b>667,183,353.00</b>	<b>550,191,973.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	53,182,733.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	53,182,733.00	00.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	27,385,000.00	35,666,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	27,385,000.00	35,666,200.00
1330	<b>Төсвийн захирагчдаас</b>	418,835,600.00	00.00
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	418,835,600.00	00.00
1340	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	167,780,020.00	514,525,773.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	167,780,020.00	514,525,773.00
2	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>666,663,084.74</b>	<b>696,303,409.56</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>666,663,084.74</b>	<b>696,303,409.56</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>632,222,253.74</b>	<b>694,129,277.86</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	377,284,574.42	381,958,726.94
210101	Үндсэн цалин	232,486,313.29	244,058,853.09
210102	Нэмэгдэл	113,756,407.29	98,941,654.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,869,911.11	4,392,999.82
210104	Урамшуулал	25,679,197.51	34,565,219.77
210105	Гэрээт ажлын хөлс	492,745.22	00.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	40,801,423.00	46,483,423.12
210201	Тэтгэврийн даатгал	29,825,356.47	32,195,110.35
210202	Тэтгэмжийн даатгал	2,569,076.21	3,662,050.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,485,022.49	2,934,613.97
210204	Ажилгүйдлийн даатгал	525,308.07	720,543.57
210205	Эрүүл мэндийн даатгал	5,396,659.76	7,331,105.06
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	24,516,169.00	29,825,868.30

210301	Гэрэл, цахилгаан	416,669.00	399,868.30
210302	Түлш, халаалт	18,279,500.00	23,606,000.00
210303	Цэвэр, бохир ус	5,820,000.00	5,820,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>47,866,662.32</b>	<b>72,352,780.00</b>
210401	Бичиг хэрэг	4,934,910.00	5,580,250.00
210402	Тээвэр, шатахуун	38,564,655.00	54,865,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,867,097.32	2,169,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,500,000.00	3,140,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	6,597,530.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>122,644,600.00</b>	<b>142,656,579.50</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	112,667,500.00	129,263,639.50
210502	Хоол, хүнс	5,977,100.00	9,326,440.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.00	4,066,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,913,000.00</b>	<b>5,438,600.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,685,000.00	3,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	153,500.00
210604	Урсгал засвар	1,228,000.00	1,535,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>756,000.00</b>	<b>2,483,800.00</b>
210702	Дотоод албан томилолт	756,000.00	2,483,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>856,325.00</b>	<b>4,709,000.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	2,791,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200,000.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	00.00	35,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,115,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	455,400.00	658,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,583,500.00</b>	<b>7,860,500.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,583,500.00	7,860,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>34,440,831.00</b>	<b>2,174,131.70</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>32,800,000.00</b>	<b>00.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32,800,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,640,831.00</b>	<b>2,174,131.70</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,640,831.00	2,174,131.70
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>520,268.26</b>	<b>24,636,060.44</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>520,268.26</b>	<b>24,636,060.44</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>520,268.26</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>520,268.26</b>	<b>25,156,328.70</b>

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-31,039,635.21	429,952,566.14
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-31,039,635.21	429,952,566.14
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-31,039,635.21	429,952,566.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	-31,039,635.21	429,952,566.14
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	71,379,818.83	71,379,818.83
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	349,821,565.00	111,170,636.35	40,340,183.62	496,741,364.92

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	659,472,100.00	709,103,409.56
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	659,472,100.00	709,103,409.56
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	659,472,100.00	706,929,277.86
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	353,831,300.00	381,958,726.94
210101	Үндсэн цалин	211,103,200.00	244,058,853.09
210102	Нэмэгдэл	104,649,400.00	98,941,654.26
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,025,000.00	4,392,999.82
210104	Урамшуулал	31,053,700.00	34,565,219.77
210105	Гэрээт ажлын хөлс	00.00	00.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	44,071,700.00	59,643,423.12
210201	Тэтгэврийн даатгал	29,968,800.00	32,195,110.35
210202	Тэтгэмжийн даатгал	3,525,700.00	3,662,050.17
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,820,600.00	2,071,017.40
210204	Ажилгүйдлийн даатгал	705,100.00	720,543.57

210205	Эрүүл мэндийн даатгал	7,051,500.00	20,131,105.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	00.00	29,825,868.30
210301	Гэрэл, цахилгаан	00.00	399,868.30
210302	Түлш, халаалт	00.00	23,606,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	5,820,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	79,278,500.00	72,352,780.00
210401	Бичиг хэрэг	6,210,600.00	5,580,250.00
210402	Тээвэр, шатахуун	54,865,100.00	54,865,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,833,500.00	2,169,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,491,100.00	3,410,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,878,200.00	6,597,530.00
<b>2105</b>	<b>Норматив зардал</b>	154,604,000.00	142,656,579.50
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	138,996,000.00	129,263,639.50
210502	Хоол, хүнс	11,541,500.00	9,326,440.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,066,500.00	4,066,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	6,316,500.00	5,438,600.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,916,500.00	3,750,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,400,000.00	153,500.00
210604	Урсгал засвар	00.00	1,535,100.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	3,526,500.00	2,483,800.00
210702	Дотоод албан томилолт	3,526,500.00	2,483,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,912,500.00	4,709,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,000,000.00	2,791,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	533,500.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	384,000.00	108,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	35,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	25,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,200,000.00	1,115,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	690,000.00	658,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	8,931,100.00	7,860,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,931,100.00	7,860,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	659,472,100.00	734,259,738.26
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	48,192,200.00	35,666,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	48,196,200.00	35,666,200.00
<b>1340</b>	<b>НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	611,275,900.00	697,763,270.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	611,275,900.00	697,763,270.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	520,268.26
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	25,156,328.70

62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	26.00	25.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	20.00	19.00
620003	Үйлчлэх ажилтан	05.00	05.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь "Үйлчлүүлэгчид нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээг түлхүү хүргэж, эрүүл амьдралын идэвхтэй хэв маягийг хэвшүүлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй аюулгүй хүргэх" гэж эрхэм зорилгоо тодорхойлж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж мөрдөж эхэлсэн байна. Дараах тогтоолуудад өөрчлөлт орж мөрдөж байна. Үүнд:

- *Засгийн газрын 2022оны 107 дугаар тогтоолоор "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай"*
- *Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот "Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай"*
- *Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай"*

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт **үр нөлөөтэй** байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд ДУНД гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналтгүй гэж үзлээ

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Алтай сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 41025.0 мянган төгрөгөөр буюу 8.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	520,2	25,676.6	25,156.4
Авлага	38,717.1	1,335.1	-37,382.0
Бараа материал	44,231,1	30,920.1	-13,311.0
Үндсэн хөрөнгө	378,925.0	445,486.6	66,561.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>462,393.4</b>	<b>503,418.4</b>	<b>41,025.0</b>
Өр төлбөр	32,440.9	1,392.6	-31,048.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	429,952.5	502,025.8	72,073.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>462,393.4</b>	<b>503,418.4</b>	<b>41,025.0</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 25.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Өмнөх онд аймгийн эрүүл мэндийн даатгалын сангаас төлбөртэй үйлчилгээний авлага 37.4 сая төгрөг байсныг тайлант онд санхүүжилтээр авч барагдуулж 1.3 сая төгрөгийн ажиллагсадтай холбоотой авлага байна.
- ✓ Бараа материал эхэнд 44.2 сая төгрөг тайлант хугацаанд 13.3 сая төгрөгийн зарлага гаргаж оны эцэст хоол 1.7 сая, эм 11.4 сая, аж ахуйн материал 12.5 сая, бусад хангамжийн материал 1.8 сая, нийт 30.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Үндсэн хөрөнгө болон тоног төхөөрөмж болох хандиваар авсан вирусийн аппарат, ОНХС-аас 15.0 сая төгрөгийн био химийн анализатор, УОК-70.0 сая төгрөгийн Пургон машин, Эрүүл мэндийн газраас 15.5 сая төгрөгийн хүчил төрөгчийн аппарат, мотоцикл, суурин компьютер, сорьц хадгалагч хөргөгч зэргийг нийлүүлсэнтэй холбоотойгоор өссөн дүнтэй байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны орон нутгийн төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 48.1 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалаас 659.4 сая төгрөг бүгд 707.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр эрүүл мэндийн даатгалын сангаас 697.7 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 35.6 сая төгрөг, өөрийн үйл ажиллагааны орлогоос 0.8 сая нийт 734.1 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	/мянган төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602/80302-нэг иргэнд ногдох нормативаар	428,0	368,1	59,9	86
2	71602/81603-үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	240,7	213,9	26,8	89
3	71602/83603 дээд шатны төсвөөс хуваарилсан	78,9	78,5	0,4	99,4
<b>ДҮН</b>		<b>747,6</b>	<b>660,5</b>	<b>87,1</b>	<b>91,5</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн тайлангийн жилд нэмэлтээр орлого, зарлагын гүйлгээ гараагүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Алтай сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Ц.Гантулга 2023 оны 02 дугаар сарын 12-ноос 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 10 албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 712.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 10.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 8.5 сая төгрөгөөр тогтоосон.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 17 байна.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, төсөв өмч, хөрөнгө, мөнгө тушаалын шийдвэрийг мэдээлээгүй 13 хуулийн хэрэгжилт 81.0 хувьтай байна.

## 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар ХХОАТ-ын хөнгөлөлтийг давхардуулан тооцсон, үр дүнгийн урамшууллыг сахилгын шийтгэлтэй эмч, албан хаагчдад олгосон, ажил хавсарсны нэмэгдэлтэй холбоотой 9.5 зөрчил илэрсэн байна.

*Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/*

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1.7	2	1.7	100
Албан шаардлага	1	2.8	1	2.8	100
Зөвлөмж	1	5.0	1	5.0	100.0
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>9.5</b>	<b>4</b>	<b>9.5</b>	<b>100</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар эмийн нийлүүлэлт, тооллого, тооцоо бодолтыг онцлон анхаарах шаардлагатай гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Залруулга хийх алдаа<sup>1</sup> илрээгүй болно.

Аудитаар нийт 134.4 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 3.8 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 129.3 сая төгрөгийн 1 албан шаардлага, 1.3 сая төгрөгийн 3 зөвлөмж өглөө.

##### 5.1 Албан шаардлага

- ✓ Эрүүл мэндийн төвийн дарга нь амбулаторийн сувилагчийг ажлаас чөлөөлсөн байна. Уг шийдвэрийг сувилагч хүлээн зөвшөөрөхгүй хууль хяналтын байгууллагад хандсанаар, шүүх нэхэмжлэгч, хариуцагч талуудын эвлэрлийн байдлыг харгалзан Эрүүл мэндийн төвийн даргын ажлаас чөлөөлсөн тушаалыг хүчингүйд тооцон хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Шүүгчийн захирамжийг үндэслэн сувилагчийн ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэл нийт 3802476.00 төгрөгийг Эрүүл мэндийн төвийн төсвөөс гаргасан байна.

Энэ нь Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.2-т "Төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл/эс үйлдэх/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана, энэ хуулийн 498.5-т энэ хуулийн 498.2-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд боломжгүй үйлдлээр гэм учруулсан бол гэм хориг арилгасан байгууллага өөр учирсан хохирлыг тухай гэм буруутай этгээдээс гаргуулахыг шаардах эрхтэй...", "төрийн албаны тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.1-д" төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

##### 5.2 Албан шаардлага

- ✓ Эрүүл мэндийн төв нь тайлант жилд 129.3 сая төгрөгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэглэлийн зардал гаргасан. Үүнээс 100.3 сая төгрөг буюу нийт эмийн зардлын 77.6 хувь нь тендерийн бусаар нийлүүлэгдсэн байна. Нийлүүлсэн эмийн дэлгэрэнгүй тайлан гаргаж тооцоо бодоогүй, эмийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудаас бөөн дүнгээр орлого авч, зарлага гаргадаг, тендерээр эм нийлүүлж байгаа компаниудын эм нийлүүлэх эрх, гэрээтэй эсэх тодорхой бус байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 37 дугаар зүйлийн 37.1.7-д "төсвийг орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох хуулийн холбогдох дансанд бүртгэх, тайлагнах, МУ-ын засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### 5.3 Зөвлөмж

#### 5.3.1 Шилэн данстай холбоотой асуудал.

Илрүүлэлт Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 142 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 17 байна.

Шилэн дансны цахим системд тендерт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг бүрэн мэдээлж, төсөв өмч ,хөрөнгө ,мөнгө тушаалтай холбоотой 13 шийдвэрийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д" Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдэгдлийг тогтмол мэдээлнэ" хуулийн заалтыг зөрчсөн байна

Өгсөн зөвлөмж Шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллаж хөрөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг бүрэн байршуулж байх

#### 5.3.2 Анхан шатны баримттай холбоотой асуудал.

Илрүүлэлт: Анхан шатны баримтын үдэлт, дугаарлалт байхгүй, эмх цэгцгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3.Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах байдлаар гүйцэтгэнэ: 14.3.1. анхан шатны баримт бүрдүүлэх гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж Анхан шатны баримтын иж бүрэн бүрдүүлж, холбогдох хууль тогтоомжийг мөрдөж ажиллах

#### 5.3.3 Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Хариуцах эзэн нь тодорхой бус 1.3 сая төгрөгийн авлага байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж : Авлагыг барагдуулах талаар тодорхой арга хэмжээ авч 2023 оны санхүүгийн жилдээ багтаан барагдуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/ сая. төгрөг/

Зөрчлийн товч утга	Үүнээс							
	Нийт алдаа		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалин хөлстэй холбоотой	1	3.8	1	3.8				
Эм,эмийн хэрэгсэлтэй холбоотой	1	129.3			1	129.3		
Анхан шатны баримтын бүрдэл сайжруулах	1						1	-
Авлагатай холбоотой асуудал	1	1.3					1	1.3

	4	134.4	1	3.8	1	129.3	2	1.3
--	---	-------	---	-----	---	-------	---	-----

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

**/мянган төгрөгөөр**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв өмч хөрөнгө, мөнгө зарцуулахтай холбоотой 13 шийдвэрийн мэдээлэл байршуулаагүй, 17 мэдээллийг хугацаа хоцроосон								
Дүн	1.0	-					1.0	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Нийт дүн								

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:** *[Signature]* **Б.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР:** *[Signature]* **А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН:**

**АУДИТОР:** *[Signature]* **Ц.ГАНТУЛГА**

